

## ЁС ЗҮЙН ДҮРЭМ

HR-0701P

|   |   |
|---|---|
| <i>Хариуцагч</i><br>М-Си-Эс Холдинг ХХК - Захиргаа, хүний нөөцийн газар | <i>Шинэчлэгдсэн огноо</i><br>2018.03.07 |
| <i>Танилцах</i><br>М-Си-Эс Группын харьяа компанийн нийт ажилтан        | <i>Хавсралт</i><br>-                    |

## БОДЛОГО / POLICY

М-Си-Эс Группийн харьяа компаниуд болон нийт ажилтнууд нь “Дэлхийн хөгжлийг Монголдоо цогцлоох” эрхэм зорилго болон бизнесийн бусад зорилго, зорилтондоо хүрэхийн төлөө ажиллахдаа тус Группийн үнэт зүйлс, баримтлах зарчмуудыг болон тэдгээрээс урган гарсан энэхүү Ёс зүйн дүрмийг өдөр тутам мөрдлөг болгоно.

## ЗОРИЛГО / PURPOSE

М-Си-Эс Группийн Ёс зүйн дүрэм нь тус Группийн харьяа компаниуд болон нийт ажилтнуудын өдөр тутмын бизнесийн үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн хэм хэмжээг тодорхойлж өгөх үндсэн зорилготой.

## ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ

- М-Си-Эс Группийн нийт компаниуд болон тэдгээрийн үндсэн ажилтнууд
- Гэрээт ажилтнууд
- Бэлтгэн нийлүүлэгчид

## М-СИ-ЭС ГРУППИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛС, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

**ЭРХЭМ ЗОРИЛГО:** “Дэлхийн хөгжлийг Монголд”

**ҮНЭТ ЗҮЙЛС:**

- Мэргэшсэн өндөр чадавхи*  
Мэргэжлийн өндөр ур чадвартай, өөрийгөө болон бусдыг байнга хөгжүүлдэг.
- Манлайлал*

Цаашдын ахиц хөгжлийн боломжийг олж тодорхойлж, бусдадаа ойлгуулан дэмжлэгийг нь авч, тэднийг урам зоригжуулан, хамтдаа бодит үйл хэрэг болгодог.

- Санал санаачилга*  
Хөгжүүлэх, сайжруулах, асуудлыг шийдвэрлэх бүтээлч шийдэл, санал санаачилгыг байнга гаргадаг.

- Багийн сэтгэлгээ*

Харилцан итгэлцэл, хүндлэл, эерэг дулаан харьцааг буй болгон хамт олонтойгоо үр дүнтэй хамтран ажилладаг.

- Өөриймсөг үзэл*

Ажилдаа болон компанидаа өөриймсөг хандаж, сэтгэл гарган ажилладаг.

- Үнэнч шударга зарчим*

Монгол Улсын хууль, журмыг алхам тутамдаа дээдэлдэг, аливаад үнэнч шударга ханддаг.

**БАРИМТЛАХ ЗАРЧМУУД:**

- Өөрийгөө болон бусдыг хөгжүүлэх нь ажилтан бүрийн эрхэм үүрэг байна.
- Бид ажилтан бүрт хөгжиж, ахиж дэвших орчныг бүрдүүлж, ижил тэгш бололцоо олгоно. Ажилтны өсөж хөгжих, дэвшиж дээшлэх нь тухайн хүний ур чадвар, гүйцэтгэл, оруулж буй хувь нэмэртэй шууд холбоотой байна.
- Бид сайн ажилчин, ажилтан, менежер төдийгүй сайн манлайлагч байхыг эрмэлзэж, үлгэр дууриал үзүүлнэ.
- Бид шинийг сэдэж, аливааг сайжруулах боломжийг цаг ямагт эрэлхийлнэ. Бид шинэ санаа, бүтээлч хандлагыг хөхиүлэн дэмжинэ.
- Бид хамгийн шилдэг шийдэл бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэнэ.
- Өндөр чадавхи, олон ургальч санаа бодол бүхий гишүүдээс бүрдсэн, харилцан итгэлцэл, хүндлэлд суурилсан хамтын зүтгэл нь бидний тогтвортой амжилтын үндэс юм.
- Группийн бүхий л түвшинд багийн тоглолт, багуудын хамтын ажиллагаа байх ёстой.
- Бид ажилдаа эзний сэтгэлээр хандаж, компанийн нэр хүнд, өмч хөрөнгийг хайрлан хамгаална.
- Бид зах зээлийн шударга зарчимд тулгуурлан харилцан биенээ дэмжиж, нөхөж ажилласнаар улам их үр дүн гаргах боломж бололцоогоо нэмэгдүүлнэ.
- Бид зөв зүйлийг зөв арга замаар хийж, хэлсэн үгэндээ эзэн байж, үүрэг хариуцлагаас зайлсхийлгүй, итгэл найдвар хүлээж ажиллана.
- Бид хууль тогтоомжийг дээдэлж ажиллана.
- Бид ажилтан, түнш, хэрэглэгчтэйгээ харилцахдаа үнэнч шударга зарчмыг эрхэмлэнэ.

**1. ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА**

- 1.1. Бид ажилтан бүртээ эрх тэгш хандан, аюулгүй, таатай ажиллах орчныг бүрдүүлдэг.
- 1.2. Бид олон ургальч, ялгаатай байдлыг үнэлж, арьсны өнгө, хүйс, иргэний харьяалал, үндэс угсаа, шашин шүтлэг, нас, бэлгийн чиг хандлагаас нь үл хамааран бүх ажилтан, түншүүдээ эн тэнцүү, хүндэтгэж харьцдаг.
- 1.3. Бид хувь хүний нэр төрд хүндэтгэлтэй ханддаг. Бусдыг ямар нэг хэлбэрээр доромжлох, тохуурхах, дээрэлхэх, айлган сүрдүүлэх, дарамтлах явдлыг хүлээн зөвшөөрдөггүй.
- 1.4. Бид хөдөлмөр эрхлэлттэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомжийг чанд сахин биелүүлдэг.
- 1.5. Бид бусдаас хууль тогтоомж, дүрэм, журмыг ямар нэг байдлаар зөрчихийг шаарддаггүй.
- 1.6. Бид ажлын цагаар ажлын байрандаа ажил хэрэгч байдлаар хувцасладаг.

**2. АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ МЭНД, БАЙГАЛЬ ОРЧИН**

- 2.1. Манай ажилтан бүр хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой хууль тогтоомж, дүрэм журам, зааврыг чанд дагаж мөрдөн, өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангаж ажиллах үүрэгтэй.

**ЁС ЗҮЙН ДҮРЭМ****HR-0701P**

- 2.2. Бид ажлын цагаар ажлын байран дээрээ ажлын бүрэн чадвартай байх үүрэгтэй. Бид ажил үүргээ гүйцэтгэхдээ согтууруулах ундаа, мансууруулах бодисын нөлөөнөөс ангид, ажил үүргээ гүйцэтгэх бүрэн чадвартай байх ёстой.
- 2.3. Ажлын байранд галт зэвсэг, хутга мэс гэх зэрэг бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй зүйлийг авчрахыг хориглоно.
- 2.4. Хэн нэгэн маань ажлаа гүйцэтгэх явцдаа өөрийн, эсвэл бусдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг эрсдэлд оруулж байна гэж үзвэл энэ талаар мэдэгдэж, ажлыг нь нэн даруй зогсоолгох үүрэгтэй.
- 2.5. Ажлын байранд хэн нэгэнд маань эрүүл мэндийн холбогдолтой ямар нэг өвдөлт, зовиур тохиолдсон бол холбогдох ажилтнуудад нэн даруй мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээг авах үүрэгтэй.
- 2.6. Бид байгаль орчиндоо ээлтэй байхыг эрхэмлэн, байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлдэг, бууруулдаг, арилгадаг, байгаль орчны холбогдолтой хууль тогтоомжийг мөрдөж ажилладаг.
- 2.7. Бид хамтран ажилладаг харилцагч, гүйцэтгэгч, бэлтгэн нийлүүлэгч болон холбогдох бусад этгээдээ манай аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд, байгаль орчны шаардлагыг хүндэтгэж, сахин мөрдөхийг хүсэн хүлээдэг.

**3. ХҮНИЙ ЭРХ**

- 3.1. Бид хүний эрхийг хүндэтгэж, хүний эрхийг ямар нэг байдлаар зөрчихгүй байхыг эрмэлздэг. Бид Нэгдсэн үндэстний байгууллагын Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг дэмждэг.
- 3.2. Бид хүүхдийн хөдөлмөр, хөдөлмөрийн мөлжлөг, албадмал хөдөлмөрийн аливаа хэлбэрээс татгалздаг.
- 3.3. Бид харилцагч, гүйцэтгэгч, бэлтгэн нийлүүлэгчдээсээ ч мөн адил хүний эрхийг хүндэтгэхийг хүсэн хүлээдэг.

**4. ХУВЬ ХҮНИЙ МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ**

- 4.1. Бид хүний хувийн нууцыг хүндэтгэдэг ба чандлан хадгалдаг.
- 4.2. Бид зөвхөн хууль ёсны бизнесийн зорилгод шаардлагатай болсон тохиолдолд л ажиллагсад, ажил горилогчид, бизнесийн түншүүд, бэлтгэн нийлүүлэгчид, худалдан авагчдын хувийн мэдээллийг цуглуулж, тэдгээр мэдээлэлтэй харьцдаг. Бид өөрийн мэдээллийг хянаж, шинэчилж, залруулах хүн бүрийн эрхийг хүндэтгэдэг.
- 4.3. Зөвхөн хууль ёсны бизнесийн хэрэгцээ гарсан, эсхүл хуулийн дагуу шаардсан тохиолдолд л хүний хувийн мэдээллийг бусадтай хуваалцдаг ба энэ тохиолдолд мэдээллийн нууцлалд тавигдах шаардлага, хэм хэмжээг тодорхой болгож өгдөг.

**5. ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН**

- 5.1. Бид зах зээл дээр шударга, ёс зүйтэй өрсөлдөж, шударга өрсөлдөөний тухай холбогдох хууль тогтоомжийг хүндэтгэн ажилладаг.
- 5.2. Бид өрсөлдөгчдийн талаарх мэдээллийг хууль бус арга замаар олж авдаггүй, өрсөлдөгчдийн талаар худал мэдээлэл түгээдэггүй, өрсөлдөгчдийн эсрэг хууль бус үйл ажиллагаанд оролцдоггүй.
- 5.3. Бид өрсөлдөгчидтэйгөө, эсвэл өрсөлдөж болзошгүй байгууллагатай харилцахдаа бидний өрсөлдөөнд нөлөөлж болох нууцлалтай мэдээллийг тэдэнд өгдөггүй.
- 5.4. Бид харилцагч, гүйцэтгэгч, бэлтгэн нийлүүлэгчиддээ ижил тэгш боломж, бололцоо олгодог, худалдан авалт, тендерийн үйл ажиллагааг холбогдох дүрэм журмын дагуу шударга явуулдаг, бизнесийн нууцыг нь бусдад задруулдаггүй.

**ЁС ЗҮЙН ДҮРЭМ****HR-0701P**

5.5. Бид аливаа зар сурталчилгааг хууль, тогтоомжийн хүрээнд явуулдаг. Худал мэдээлэл агуулсан буюу буруу ойлголт төрүүлэхүйц зар сурталчилгаа явуулдаггүй.

**6. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ**

- 6.1. Бид компанид үүрэг, хариуцлага хүлээсэн албан тушаалтны хувьд компанийн хууль ёсны эрх ашгийг энэ тэргүүнд эрхэмлэн ажиллах үүрэгтэй.
- 6.2. Хувийн ашиг сонирхол маань компанийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагатай зөрчилдөхгүй байхад анхаарч ажилладаг.
- 6.3. М-Си-Эс Группд хашиж буй албан тушаал, ажил үүргээ ашиглан далдуур өөртөө давуу байдал бий болгохыг зөвшөөрдөггүй.
- 6.4. Бид ашиг сонирхлын зөрчил үүсэхээс болон ашиг сонирхлын зөрчилтэй мэт харагдахаас аль болох зайлсхийдэг.
- 6.5. Бид ашиг сонирхлын бодит болон болзошгүй зөрчлийг урьдчилан мэдүүлдэг. (М-Си-Эс Группийн “Ашиг сонирхолын зөрчлийг мэдүүлэх журам”)

**7. АВИЛГА, ХЭЭЛ ХАХУУЛЬ**

- 7.1. Хэн нэгнээр хийх ёсгүй зүйл, зохисгүй үйлдэл хийлгэх, эсвэл хийвэл зохих зүйлийг нь хийлгэхгүй байхын тулд бэлэг, төлбөр, давуу тал өгч ятгахыг бид авилга, хээл хахууль гэж үздэг ба бид бусдад авилга, хээл хахууль санал болгодоггүй, өгдөггүй.
- 7.2. Хэн нэгэн хийх ёстой зүйлээ хийхдээ бусдаас бэлэг, төлбөр нэхэхийг бид мөн авилга, хээл хахууль гэж ойлгодог ба ийм саналыг хүлээж авдаггүй.
- 7.3. Бид авилга, хээл хахууль авдаггүй. Бид ажлаа хийхдээ бусдаас санхүүгийн, өөр бусад давуу тал шаарддаггүй, ийм давуу тал, урамшууллын нөлөө ятгалгад орж зүй бүс үйлдэл гаргадаггүй, компанийн өмнө хүлээсэн үүргээ зөрчдөггүй.

**8. ТӨР, ЗАСАГ**

- 8.1. Компанийн хувьд бид улс төрд оролцдоггүй, Монгол Улсын хууль тогтоомжоос гадуур аль нэг улс төрч, улс төрийн хүчинд хандив өгдөггүй.
- 8.2. Бизнесийн орчинд нөлөөлөх төр, засгийн бодлого, хууль эрх зүйн асуудалд бид санал бодлоо илэрхийлэх, холбогдох мэдээлэл өгөх байдлаар оролцдог.
- 8.3. Бид бизнесийн үйл ажиллагааныхаа талаар үнэн зөв мэдээллийг төрийн эрх бүхий байгууллагад хуулийн дагуу гаргаж өгдөг.

**9. КОМПАНИЙН ӨМЧ, ХӨРӨНГӨ**

- 9.1. Бид компанийн өмч хөрөнгө, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг гагцхүү компанийн албан хэрэгцээнд ашигладаг ба албан ёсны зөвшөөрөлгүйгээр хувийн эрх ашгийн төлөө ашигладаггүй.
- 9.2. Ажлаа хийхэд маань бидэнд тус дэм болгож ашиглуулдаг компьютер, цахим шуудан, интернет гэх зэрэг хэрэгслийг компанийн үйл ажиллагаанд нөлөөлөхгүй, компанид зүй бус зардал учруулахгүй, ажил үүргээ явуулахад маань саад болохгүй бол хувийн зорилгодоо хааяа ашиглаж болно.
- 9.3. Бид компанийнхаа оюуны өмчийг хамгаалж, бусад этгээд зөвшөөрөлгүйгээр ашиглаж буй эсэхийг хянадаг ба мөн бусдын оюуны өмчийг хүндэтгэж, албан ёсны зөвшөөрлийг нь авсны үндсэн дээр л ашигладаг.
- 9.4. М-Си-Эс Группийн дүрэм журмаас гадуур компанийн өмч хөрөнгө, тэдгээрийн бүртгэлд өөрчлөлт, хасалт хийхийг болон устгахыг хориглодог.

**ЁС ЗҮЙН ДҮРЭМ****HR-0701P****10. БИЗНЕСИЙН НУУЦ МЭДЭЭЛЭЛ**

- 10.1. Нууц мэдээлэл гэдэгт бизнесийн стратеги, төлөвлөгөө, ажиллагсдын мэдээлэл, харилцагч, бэлтгэн нийлүүлэгчдийн жагсаалт, санхүүгийн мэдээлэл болон бизнесийн үйл ажиллагааны талаарх олон нийтэд зарлаагүй аливаа мэдээлэл орно.
- 10.2. Бид нууц мэдээллийн талаар хаана, хэнтэй ярихаа, хаана, хэрхэн хадгалахаа сайн бодож, хянамгай хандах үүрэгтэй.
- 10.3. Бид хувийн ашиг хөөх, давуу байдал олохын тулд ямарваа нууц мэдээллийг ашигладаггүй, задруулдаггүй.
- 10.4. Бид компанийн бизнесийн дотоод мэдээллийг бусад хүмүүстэй, тэр дундаа гэр бүл, найз нөхөдтэйгөө хуваалцдаггүй.

**11. ТАЙЛАН, МЭДЭЭ**

- 11.1. Бид аливаа тайлан, мэдээг цаг хугацаанд нь үнэн зөв, нягт нямбай гаргаж тайлагнах үүрэгтэй.
- 11.2. Албан бичиг, санхүүгийн болон бусад баримт, тайлан мэдээг хуурамчаар үйлдэхийг хориглодог.
- 11.3. Ажилд шаардлагатай мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулахыг хориглодог.

**12. ЗӨРЧЛИЙГ МЭДЭЭЛЭХ**

- 12.1. Ажилтан нь Монгол Улсын хууль тогтоомж болон энэхүү Ёс зүйн дүрэмд заасан хэм хэмжээг зөрчсөн, зөрчигдөж байгааг мэдсэн бол энэ тухай компанийн ёс зүйн зөрчлийг шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.
- 12.2. Компани нь зөрчлийн талаарх мэдээллийг тухай бүр хүлээн авах, мэдээлэгчийн нууцлалыг хадгалах үүрэгтэй.
- 12.3. Зөрчлийн талаарх мэдээллийг амаар, бичгээр болон цахим шуудангаар хүргүүлж болох ба ажилтан нэрээ нууцлах зорилгоор нэргүй мэдээллийг компани дээр байршуулсан “Санал, гомдол хүлээн авах хайрцаг”-т хийж болно.
- 12.4. Зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авсан эрх бүхий албан тушаалтан нь зөрчлийг санаатай болон санамсаргүй байдлаар нуун дарагдуулах, дарамт, шахалт үзүүлэхийг хориглоно.
- 12.5. Мэдээлэгчийн хүсэлтээр зөрчлийг шийдвэрлэсэн байдал, авсан арга хэмжээний талаар эрх бүхий албан тушаалтан танилцуулж болно.

**13. ЗӨРЧЛИЙГ ШИЙДВЭРЛЭХ**

- 13.1. Энэхүү дүрмийг мөрдүүлэх, болзошгүй зөрчлийг шийдвэрлэх эрх бүхий Ёс зүйн хороог, эсхүл албан тушаалтныг М-Си-Эс Группийн хувьд М-Си-Эс Холдинг ХХК-ийн Захирлуудын зөвлөлийн тогтоолоор, охин компанийн хувьд тухайн компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар томилно.
- 13.2. Охин компани нь Группийн Ёс зүйн дүрмийн хүрээнд өөрийн үйл ажиллагааны онцлогт нийцүүлсэн ёс зүйн дүрэмтэй байж болно.
- 13.3. Ёс зүйн дүрмийг мөрдүүлэх, болзошгүй зөрчлийг шийдвэрлэх эрх бүхий Ёс зүйн хороо буюу албан тушаалтан нь дараах эрх, үүрэгтэй байна:
  - 13.3.1. Ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, мөрдүүлэх;
  - 13.3.2. Ёс зүйн болзошгүй зөрчлийн талаар мэдээлэл авснаас хойш ажлын 10 хоногийн дотор холбогдох этгээдүүдээс дэлгэрэнгүй мэдээлэл, баримт, тайлбарыг авч, дүгнэлт

**ЁС ЗҮЙН ДҮРЭМ**

**HR-0701P**

гарган Гүйцэтгэх захиралд танилцуулж, шаардлагатай бол холбогдох шийдвэрийг гаргуулах.

- 13.4. Ёс зүйн дүрмийн болзошгүй зөрчлийг охин компанийн түвшинд шийдвэрлээгүй тохиолдолд М-Си-Эс Холдинг ХХК-ийн Ёс зүйн хороонд хүргүүлэн шийдвэрлүүлнэ.

**14. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА**

- 14.1. Энэхүү дүрмийн хэрэгжилтэд М-Си-Эс Холдинг ХХК-ийн Ёс зүйн хороо, компанийн Гүйцэтгэх захирал болон холбогдох албан тушаалтан хяналт тавьж ажиллана.
- 14.2. Ёс зүйн дүрмийг мөрдүүлэх, болзошгүй зөрчлийг шийдвэрлэх эрх бүхий Ёс зүйн хороо буюу албан тушаалтны гаргасан дүгнэлтийг үндэслэн зөрчил гаргасан ажилтанд Гүйцэтгэх захирлын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулна.
- 14.3. Ёс зүйн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хууль, хяналтын байгууллагад шилжүүлнэ.